



81

**НИЙСЛЭЛИЙН
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 12 сарын 10 өдөр

Дугаар М/23

Улаанбаатар хот

**Өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэх
ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 214 дүгээр захирамж, Нийслэлийн Засаг дарга бөгөөл Улаанбаатар хотын Захирагчийн А/1538 дугаар захирамж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 122 дугаар тогтоолоор батлагдсан Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.8 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэх чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Д.МӨНХТОГТОХ

Захиргааны албаны Ахлах мэргэжилтэн

Гишүүд:

С.ОТГОНБААТАР

Хуулийн зөвлөх

Б.МӨНГӨНХУЯГ

Үйлдвэрлэл, технологийн албаны

Ахлах мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:


М.МӨНХДУЛАМ

Бичиг хэрэг, архив, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн

2. Байгууллагад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдолд тусгагдсан асуудлыг өөрийн эрхлэх асуудлын хүрээнд судалж, шуурхай, хууль зүйн үндэслэлтэй шийдвэрлэж, хариу өгөхийг Ажлын хэсэг (Д.Мөнхтогтох)-т үүрэг болгосугай.

3. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс 25-ны өдрийг хүртэлх хугацаанд тухайн өдрийн 16:00 цагаар тасалбар болгон батлагдсан маягтын дагуу Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Нарийн бичгийн дарга (М.Мөнхдулам)-д даалгасугай.

4. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны алба (Д.Мөнхтогтох)-нд даалгасугай.



ДАРГА

Ч.ЭЛБЭГСАЙХАН